

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

|  |      |
|--|------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>   | 1    |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | 2-3  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | 4-19 |

---

|  |      |
|--|------|
| 1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 4-19 |
|--|------|

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Өргөдлийн байнгын хорооны 05 дугаар сарын 13-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 17 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Гантулга, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Х.Жангабыл.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын дарга Т.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Л.Хосбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн, С.Уянга нар байлцав.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, С.Ганбаатар, Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 53 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 10 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 15 цаг 17 минут

### ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**О.Номинчимэг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Халтмаагийн Баттулга гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн байна аа.

Нийт 21 Байнгын хорооны гишүүнээс 16 гишүүн оролцож байна. Өнөөдөр хэлэлцэх асуудлыг Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал өнөөдөр хэлэлцэнэ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл Засгийн газраас 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн. Бүх Байнгын хороогоор хэлэлцүүлэгддэг. 2 дахь хэлэлцүүлгийг хийж санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ ээ.

Өнөөдөр энэ асуудал бүх Байнгын хороодоор орж байгаа. Тэгээд өмнөх ТББХ ирц нь бүрдэх асуудал, хуралдаан нээх асуудал нэлээн хойшилсноос үүдээд манай Байнгын хороо 14 цагт товлогдсон, 14 цагт ирц нь бүрдсэн байсан боловч өмнөх Байнгын хорооны хуралдаан ирцийн сахилга батаас болоод ингээд бүхэл бүтэн нэг цаг 20 минутын дараа ажлын хэсэг маань орж ирэх боломжтой болоод бид эхэлж байна гэдгийг бас тэмдэглэе.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу? Алга байна. Гишүүд маань түрүүн бас нэлээн хүлээж байгаад гишүүдийгээ оруулж ирэх асуудал дээр манай ажлын алба анхааръя аа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний  
мэдэгдэл 2028-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн  
хоёр дахь хэлэлцүүлэг**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг Хөгжлийн сайд Энхбаяр сайд оролцож байна. Даваасүрэн Эдийн засаг хөгжлийн дэд сайд оролцож байна. Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн оролцож байна. Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн оролцож байна. Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга оролцож байна, ЗГХЭГ-ын Засгийн газрын Хүний нөөцийн газрын дарга Гантогтох оролцож байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан оролцож байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Мөнгөнсүх оролцож байна. Эдийн засаг хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ оролцож байна. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж оролцож байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Мягмардорж оролцож байна. Эдийн засаг хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Мөнхдэлгэр оролцож байна. Эдийн засаг хөгжлийн яамны Хөгжлийн төсөл хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Төгөлдөр оролцож байна. Эдийн засаг, хөгжлийн яамны салбар дундын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Райынбек оролцож байна. Эдийн засаг хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга Чандмань оролцож байна, НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Эрдэнэбадрах оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.2-т Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж гишүүд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэж заасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд хуулийн төсөл нэг зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү. Нэг л зүйлтэй төсвийн хүрээний мэдэгдлээ өнөөдөр хэлэлцэнэ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр 3 гишүүнээр тасаллаа. Ирцийн дагуу Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

**Д.Рэгдэл:** Тэгэхээр энэ төсвийн хүрээ, төсөөлөлтэй холбогдуулаад энэ хүн болгон л ярьж байгаа. 2027 оны төсөв рүү ер нь нэлээн асуудал хүндрэл ч ирэх нь л гэсэн юм яригдаад байгаа. Тэгэхээр энэ төсвийн хүрээг гаргахдаа энэ төрийн албан хаагчдын цалингийн асуудлыг ер нь яаж бодож базаж оруулсан юм бол. Яагаад вэ гэвэл одоо энэ чинь багш, эмнэлгийн ажилтан, эмч, эмнэлгийн ажилтны цалинг нэлээн нэмчихсэн. Тэгэхээр зэрэг цаана нь нэг үлдэж байгаа бараг ойролцоо тооцоогоор бодоход 40 гаруй мянган төрийн албан хаагч байгаа. Тэд нарын цалин хөлс нөгөө эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсдынхаас хамаагүй ялгаатай байж ерөөсөө огт болохгүй шүү дээ. Энэ чинь Үндсэн хуультай бараг холбоотой

асуудал. Тэгэхээр энэ улсуудын цалинг ер нь яаж оруулж ирэхээр энд тооцсон юм бол оо гэсэн 1 дүгээр асуудал.

Хоёр дахь асуудал тэтгэврийн тухай асуудал байгаа юм аа. Энэ 2023 оны Засгийн газрын 238 дугаар тогтоолоор цалин, тэтгэвэр тогтоолгох цалин, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг олон шатлалтай тогтоогоод гаргачихсан. Тэгээд тэр мөрдөгдөөд яваад байгаа юм. Тэгээд энэ дээр хараад байхад энэ олон шатлалтай хугацаанаас хамаарсан энэ тэтгэвэр тогтоох дээд таазнаас болоод энэ нь алсдаа энэ тэтгэврийн зөрөөг багасгах асуудлыг улам хүндрүүлээд байх шинжтэй болоод яваад байна. Тэгэхээр зэрэг энэ хамгийн доод талын хэмжээ нь юу байсан гэхтэй зэрэг 2013 оны 9 дүгээр сарын 1-ээс өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэвэр тогтоох цалин орлогын дээд таазыг 1 сая 404 мянган төгрөгөөр тогтоочихсон. Энэнээс болоод үндсэндээ энэ яамнаас гаргаж байгаа мэдээллээр бол 140 гаруй мянган тэтгэвэр авагч ахмадын тэтгэвэр бага ер нь бага тогтоогдсон, тайрагдсан энэ тэр гээд маш их олон гомдол байгаа юм аа.

Тэгэхээр энэ тэтгэврийг нэмэгдүүлэх асуудлаа бас яаж тооцсон юм бол? Энэ 2 асуудалдаа нэг хариу авъя даа. Одоо яг энэ манай Өргөдлийн байнгын хороон дээр иргэдээс ирж байгаа санал хүсэлт өргөдлийн дагуу бид ажилладаг. Энэ дээр энэ Рэгдэл гишүүний асууж байгаа энэ тэтгэврийн асуудал маш чухлаар явж байгаа. Бараг ирж байгаа өргөдлийн 3-ны 1 нь энэтэй холбоотой байгаа. Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Бид багш, эмч, багш, эрүүл мэнд, боловсролын салбарынхаа ажилтан албан хаагчдын цалинг нэлээн өндөр хувиар нэмэгдүүлсэн. Энэнтэй холбоотой 2027 онд 4 их наяд төгрөгөөр урсгал зардал нэмэгдэх хэрэгцээ үүсээд байгаа. Тэгээд урсгал зардал нэмэгдэхээр ирэх онд шинээр хийх хөрөнгө оруулалт яг тэр хэмжээнд л багасаад, шинээр хийх хөрөнгө оруулалт байхгүй. Үндсэндээ 2.2 их наядын үргэлжилсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх орон зай үүсэж байна. Энэ дээр мөн адилхан тэтгэврийн асуудал байгаа.

Ноднин тэтгэврийг инфляцтай уялдуулан нэмсэн. Энэ жил тэтгэврийг бид нар инфляцыг нэг 8-10 хувьд байх болов уу гэсэн тооцоогоор төсвийн хүрээнд орон зайг нь гаргасан. Мөн адилхан төрийн албан хаагч дээр 2 жилийн өмнө төрийн албаны нэг цалинг маш сайн нэлээн бараг 50 хувь нэмсэн байгаа. Үүнээс цааш ингээд инфляцтай уялдуулан нэмэх ийм бодлого тэр хүрээ орон зайг нь гаргасан. Тэрнээс огцом нэмэгдүүлэх эрс өсөх бололцоо төсвийн боломж нэлээн хязгаарлагдмал байгаа. Тэгээд тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулаад 1 дүгээр сарын 1-ээсээ нэмнэ гэдгээрээ явна. Тэгээд яг хэдэн төгрөгөөр нэмэх асуудал бид нар хүрээ дотроо эх үүсвэр гаргачихсан. Энэ дээр Сангийн яам тооцоогоо хийгээд оруулж ирнэ.

Цалин тэтгэвэр. Тэгэхээрээ манай төсвийн бодит чадавх маань үндсэндээ ингээд ханаж эхэлж байна. Орлого зарлагын хэмжээ. Гол эдийн засгийн өсөж байгаа гол аж үйлдвэрлэл, экспорт, импортын гол тоонууд тэр бас дээд потенциалдаа хүрч эхэлж байгаа. Тасралтгүй төсвийн гол бүрдүүлж байгаа 5 гол татварын орлого байнга л нэмэгдэж ирсэн. 2027 ондоо бид 10 хувийн өсөлттэй байгаа. Тэгэхээр энэ эдийн засгийн өсөлт бидний нийгэм эдийн засгийн шаардлагыг яг гүйцэхгүй байгаа. Тэгэхээр бидэнд эдийн засгаа тэлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлээ дэмжих, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах ийм бодлогын эрх зүйд энэ томоохон арга хэмжээг төлөвлөж авч хэрэгжүүлэхээр бэлдэж байна. Ингээд Эдийн засгийн эрх чөлөөний тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Худалдааны

тухай, Төр хувийн хэвшлийн энэ түншлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох, Төрийн хяналт шалгалтын хуулийг Төр иргэний хяналт шалгалтын тухай хууль болгон шинэчлэн боловсруулаад дууссан өргөн баримт.

Ингээд төрийн өмчийн менежментийг, компаниудын менежментийг сайжруулах төрийн албаны бүхий л үе шатад дүн шинжилгээнүүд ид хийгдэж байна. Өнөөдөр эхний ээлжид яамдын түвшинд гараад яамдын чиг үүрэг давхардсан чиг үүргүүдээ цэгцлэх, уялдуулах ийм үүрэг өгөгдөөд явж байна. Төрийн өмчийн харьяа компаниуд дээр мөн адил энэ хийгдэж байна.

**О.Номинчимэг:** Рэгдэлгишүүн тодруулъя.

**Д.Рэгдэл:** Ер нь яах вэ 2027 оны төсвийн байдал хүндрээд байгааг бид нар бас гадарлаж л байгаа. Тэгэхээр бид нар 2026 оны төсөвт төрийн албан хаагчдын цалинг огт нэмэхгүй гэж оруулж ирээд Засгийн газраас, тэгээд ерөнхийдөө төсвөө бараг задлаад хаячихсан. Тэгэхдээ зэрэг энэ цалин нэмэгдээгүй төрийн албан хаагчдын цалин дээр ер нь л нэмэх талынхаа юмыг л бодож л оруулж ирвэл их чухал байна аа. Энэ бас ноднингийнх шиг болоод нөгөө оруулж ирсэн төсвөө задлаад хаячихвал ер нь хөрөнгө оруулалт чинь бараг тэг заагаад уначих вий гэсэн нэг ийм болгоомжлол байгаад байгаа юм.

Хоёрдугаарт тэтгэврийг одоо энэ тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг хүмүүс байна. Одоо нэг 250 гаруй мянган тэтгэвэр авагч байгаа байх тэтгэврийн доод хэмжээгээр. Энэ бол үнэндээ тэр ахмад настан улсууд өдөр тутмынхаа хамгийн амин чухал хэрэгцээгээ хангаад амьдраад явахад ер нь хүрэлцээ их муутай. Тэгэхээр энийг угаасаа Ахмадын тухай хуулиараа инфляцтай уялдуулж байгаад 1 сарын 1-ээс нэмэх байх тийм ээ.

6-аас 8 хувь гэж сайд хэлж байна. Тэр хавьд л нэмнэ гэдэг нь хуульчилчихсан асуудал. Гэтэл энэ бага тэтгэвэр авч байгаа улсуудын тэтгэврийг арай нэг өөр хувилбараар нэмэх талаар та бүхэн маань бас бодож тооцож үзээрэй. Асуулт ерөнхийдөө хариугаа авчихлаа. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Саяын Рэгдэл гуайн энэ асуудал бол манай Өргөдлийн байнгын хорооны гол асуудал л даа. Бүүр ард иргэд бүсээ чангалаад тасрах хэмжээнд оччихсон, тэгээд би зүгээр ганцхан юм нэмээд асуухад хариулчихна биз богинохон. Энэ төрийн албан хаагчид байна. Жирийн хөдөлмөр хийж байгаа хүмүүсийн төлөөллийн байгууллагатай та нар зөвшилцөж энэ төсвөө оруулж ирсэн үү? Хуулиараа зөвшилцөж тэднээс бүүр окэй гэж сонсчихоод орж ирэх ёстой шүү хуулиараа. Тэгэхлээр зөвшилцөөд нөгөөдүүл чинь хамтдаа бүсээ чангалъя гэж хэлсэн гэж надад хариулт өгнө гэж би найдаж байна.

Хоёрдугаарт би эдийн засгийн асуудал хариуцаж байгаа учраас энэ асуудал эдийн засаг гэдэг бол хүмүүсийн амьжиргаа шүү бас.

Хоёрдугаарт миний тодруулах асуулт гэвэл газрын тосны боловсруулах үйлдвэрийн асуудлыг энэ Өргөдлийн байнгын хороон дээр асар их асуудаг юм аа. Эдийн засгийн энэ яам том төслүүдээ бас нэлээн хүч өгч хариуцаж байгаа болов уу гэж би найдаж байна, горьдож байна. Тэгэхээр төслийн хуудас 62, 5 дугаар бүлэгт

хавсралт гэснийг та нар нэг хараадах даа. Энэ дөнгөж эхлээд орж ирэхэд би энийг асуугаагүй. Үгүй мэдээж энэ элементарны юмыг засаад орж ирэх болов уу гэсэн. Энэ 2 дугаар хэлэлцүүлэг дээр бас засахгүй орж ирж байна. Энэ дээр 4 том төслөө оруулж ирж ярьж байхдаа та нар газрын тосны боловсруулах үйлдвэрийн төслийн нийт хариуцагч нь хэн бэ гэсэн хариуцагч энэ дээр байхгүй. Нөгөө 3 дээр нь байна лээ. Байхгүй бол хэн бэ? Мэдээж би ойлгож байна. Тэгэхдээ энэ дээр яагаад бичээгүй юм бол оо.

Хоёрдугаарт төсөл эхлэх огноо бас байхгүй. Нөгөөдүүл дээр нь байна лээ нөгөө 3 дээр нь. Энэ хэд юм бэ? Та нар миний юмыг ойлгож байна уу үгүй юу энэ энэ зөв байгаа биз?

Гуравдугаар асуулт Бүс нутаг бас байхгүй. Нийт төсөвт өртөг нь 55.7 тэрбум төгрөг гэж нэг байгаа. 6.01 их наяд гэж 2 тоо байгаа. Яагаад энэ 2-ыг бичсэн юм бэ? Хоёулаа яг адилхан. Нийт төсөвт өртөг гээд нэг нь 55.7, нөгөөдөх нь 6.01 их наяд. Ингээд энийгээ надад тодруулсны дараа би бас тодруулж хэлсний дараа би асуух байх гэж найдаж байна. Газрын тосны боловсруулах үйлдвэрийн төсөл зээлээ ашиглаж чадахгүй байгаа. Би бол бүүр бардам хэлж байгаа шүү дээ. Энэ үйлдвэр чинь ажиллахгүй шүү дээ. Та нар бол мөнгө угаалт том луйврын нэг хэсэг болчихоод байгаа шүү дээ? Тэрийг бол би өнөөдөр энд ярих гээгүй. Ямар ч усны нөөц тогтоогдоогүй, ТЭЗҮ байхгүй. ТЭЗҮ дээр гарын үсэг зурсан хүн байхгүй. Тэрийг бол би хариуцсан яамнаас нь асууна. Миний саяын 4 асуултад хариулт аваад би дараа нь бас тодруулъя аа.

**О.Номинчимэг:** Хэн хариулах юм? Энхбаяр сайд. Эдийн засаг, хөгжлийн сайд.

**Ж.Энхбаяр:** Газрын тос хөтөлбөрийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хариуцаж байгаа. Эрдэс баялаг аж үйлдвэрийн яам. Монгол Улсын хамгийн сул тал бол 100 хувийн гадаад хамаарал бүхий шатах тослох материал. Энийгээ бид нар дотооддоо дотоодын эх үүсвэр дээрээ тулгуурлаад боловсруулах нь чухал гээд 1.5 сая тонн газрын тос боловсруулах ийм үйлдвэрийг Энэтхэгийн Засгийн газрын зээлээр барьж байгаа. Энэ Энэтхэгийн Засгийн газрын гадаадад хэрэгжүүлж байгаа хамгийн том төсөл. Төслийн эрчимжилт өндөр явж байна. Байшин барилга угсралт, тоног төхөөрөмжийн захиалгууд хангалттай сайн явна. Одоо бид түүхий тосоор хангах асуудал дээр та асуудал ярьж байна. Түүхий тосыг Монголын зүүн бүсийн нефтийн сав газраас татна. Тэнд бол тодорхой нөөц батлагдсан, ашиглаж явж байгаа экспорт хийгдэж байгаа. Мөн бусад манай хойд хөршид түүхий тос экспортолж байгаа томоохон экспортлогч орон байгаа. Тэнд энийгээ төмөр замынхаа дэд бүтцийг тулгуурлаад бас түүхий тосоо хангамжаа хийх бололцоотой гэж үзэж энэ байрлалыг сонгож ажил эхэлсэн.

Тийм болохоор одоо төсөл эрт тасралтгүй эрчимтэй явж байгаа санхүүжилт ямар нэгэн алдаа оноо гараагүй саатаагүй ажил үргэлжилж байгаа. Шаардлагатай гэвэл зөвхөн газрын тосны алтан ширээгээ нефть боловсруулах үйлдвэрийн цогцолборын талаар танилцуулга хийж болохоор байна гэж.

Зөвшилцөх асуудал дээр энэ гол нь макро эдийн засгийнхаа мэргэжлийн байгууллагуудын хувьд хийж байгаа Монгол банк, статистик Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Сангийн яам гээд мэргэжлийн байгууллагууд судлаачдын хүрээнд асуудлаа ярилцаад тоогоо тохироод дүн шинжилгээгээ хийгээд макро хүрээгээ гаргаж байна. Намар төсвийн хуулиар бид 9 сард өргөн барьдаг болчихсон, 9 сард

хэлэлцдэг болчихсон. Хэлэлцүүлэг дээрээ олон нийтийн хэлэлцүүлэг саналыг авдаг ийм шинэ хуультай болчихсон болохоор төсөв дээрээ их задалж ярьдаг болно оо. Энэ бол ер нь макро эдийн засгийн 9 тоогоо л бид нар тойрч ярина шүү дээ.

**О.Номинчимэг:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулъя.

**С.Ганбаатар:** Энхбаяр сайд ажил аваад бас юм бүтээж юм үр дүн гаргая гээд улайраад зүтгэж байгаа гэж би итгэж байгаа. Тэгээд дэмжих ёстой газрын тосны үйлдвэрийг бүгдээрээ бид мөрөөдөж байгаа. Тэгэхдээ бидний мөрөөдөл дээр тоглож бид ёстой аймшигтайгаар луйвардуулах гэж байгаа, луйвардуулж байна аа. Тэгээд би Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам руу асуусан асуултуудаа ойрын үед би бичгээр та бүхэн рүү асууя. Нөөц байхгүй, ус байхгүй, та нарын тэр нөөцийг чинь бүрдүүлж байгаа гээд байгаа Дайчин тамсаг ямар ч бичиг өгөөгүй. Та нар дайчин тамсгийн хажууд байгаа нөгөө 2 цооногоос ухна гэж байгаа бол худлаа. Ямар ч мөнгө байхгүй. Энэ болгон дээр би цаасаар саяын ярьсан өөдрөг энэ хариултуудыг би авна гэж найдаж байгаа. Минут байгаа учраас би бичгээр асууя даа тэднүүсийгээ. Тэгээд 1 дүгээр хэлэлцүүлгээ, эд нар хэлэлцэх эсэх дээр баахан яригдсан зүйлийг би дахиад 2 дугаар энэ хэлэлцүүлэг дээр лавлаад асууя. Тоймтой хариулт өгөөгүй учраас асууж байгаа юм шүү. Энэ өргөн барьсан төслийн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг аль субъект нь таамаглаж тодорхойлдог юм бэ? Би тэр 125 гээд тэнгэрийн тоо тавьчаад тэрэндээ чирэгдэж бид үхэх нь ээ. Энэ төсөв нэг хэдхэн сарын дараа дэндүү өөдрөгөөр гээд баахан худлаа юм ярихаас өмнө энийг хэн таамагладаг юм? Хэн нь субъект энэ бие даасан хөндлөнгийн субъект нь энэ дээр хэн бэ? Энэ бол төсвийн дүгнэлт хийдэг тэр байгууллагууд үнэхээр сайн дүгнэлтүүд хийсэн шүү. Бид чинь өөрсдийгөө тэгээд л нэг л гишүүн болчихоод л, сайд болчихоод л аймшигтай ухаантай гээд үнэнээсээ итгэххээд яваад байдаг шүү дээ. Тэгэхээр бие даасан хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт нь гарсан уу хэн дүгнэдэг юм бэ энийг гэсэн би маш энгийн асуултыг асууж байна. Хариулт авъя.

**О.Номинчимэг:** Манай техникийнхэн анхаараарай. Тодруулга нэг минут байдаг шүү. Сая өөр тоогоор өөр минутаар яваад байна. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэргүүн шадар сайд.

**Ж.Энхбаяр:** Энэ 2 түүхий эдээр авч байгаа. Зэс, нүүрс. Нүүрсээ авахдаа бид нар энэ чинь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр ингээд хуульчлаад заагаад өгчихсөн. Өнгөрсөн 20 жилийн зах зээлийн үнийн дундаж тэгэхээр энэ зарим үед манай нүүрс маань 300, 400 хүрээд их өндөр ханш тогтчихсон. Доошоо унаад бид нар 20, 30 хүртэл унасан. Энэ 2-ын хооронд чинь л нүүрсний салбарын хэлбэлзэл нь 20 жил гарчхаж байгаа. Өнөөдрийн бодит өдөр бид нар үнэнээр 68-70 дээр тооцож байна. Яг дунджаа аваад үзэхээр чинь 124 гэж гарч ирээд байгаа юм. Тэгэхээр энэ бол төсөвт нөлөөлөх нөлөөлөл байхгүй. Хамгийн гол нь нөгөө тогтворжуулалтын санд орох мөнгөгүй болчихно гэсэн үг. 124-өөс илүү гарч байж л Тогтворжуулалтын сан руу л тэр мөнгө шилжинэ гэсэн үг шүү дээ. Тэгэхээр тэнцвэржүүлсэн үнэ 124 байхад төсвийн тооцоолол 70л байхад энэ хооронд хоосон дутуу үүсэж байна гэсэн үг. Энэ 124-өө давж байж тогтворжуулалт руу буюу ирээдүйд зарцуулах эх үүсвэр бүрэлдэх юм. Тэгэхээр тэр эх үүсвэр л бүрэлдэхгүй байгаад байгаа болохоос биш төсөвт нөлөөлөх нөлөөлөл байхгүй.

Зэс дээр бол энэ чинь бид нар зэсийн тогтворжуулалтын үнэ бага байгаад байдаг. Зэс өнөөдөр гэхэд 14 мянга давчхаж байгаа байхгүй юу. Тэгэнгүүт зэсээс тогтворжуулалтын сан руу илүү ороод эхэлж байна гэсэн үг. Тооцохгүй тооцохгүй

хуультай тийм. Тийм Төсвийн тогтвортой байдлын хуулиар 20 жилээ үзнэ. Тэгээд ирэх 3 жилийнхээ зах зээлийн хандлага олон улсын байгууллагуудын дүн шинжилгээ дээр тулгуурлаад тэгээд 124 гэдэг тоо гараад л ингээд явж байгаа. Энийг бас яг бид нарын хувьд нэг их сонин огцом өсөлт, огцом уналт тэгээд энэ яг бодит юмаа уул нь жоохон буулгачихмаар л байгаа юм л даа. 180-аас нэг 90-ийн хооронд байж байхад яг л зах зээлийн дундаж ханш тогтоод л. Энүүгээрээ бид нар тогтворжуулсан сандаа мөнгөө хураагаад тэгээд эдийн засгийн ямар нэгэн хямрал жоохон нөлөөлөл орж ирнэ.

**О.Номинчимэг:** Энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хэлэлцүүлгийн дэг нь энгийн хуулиас арай өөр. Асуулт гишүүдээс 3 минутад, нэмэлт тодруулга 2 минут юм байна нэг удаа. Өөр юм байна. Галбадрах гишүүнийг асуулт асуух гишүүдэд нэмье. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

**Х.Баасанжаргал:** Би 1 хоёрхон зүйл тодруулаадахъя.

Нэгдүгээрт энэ нөгөө манай Өргөдлийн байнгын хороон дээр хүүхдийн үдийн хоолны асуудлаар ажлын хэсэг байгуулагдаад иргэдээс бас удаа дараа өргөдөл ирээд бид нар мэдээллийг бас сонсоод ингээд явж байгаа. Мөн холбогдох Боловсролын яам гээд холбогдох яамдуудаас мэдээлүүдийг авсан байгаа. Тэгэхээр энэ бас хууль нь батлагдсан. Бид нар хэрэгжих хугацаагаа хойшлуулчихсан л яваад байгаа. Тэгэхээр яг энэ үдийн хоол буюу ахлах дунд ангийнхныг үдийн хоолоор хангах энэ урсгал зардал нэмэгдэнэ гэсэн үг шүү дээ тэ. Тэгэхээр энэ орон зайг та бүхэн юу гэж харж байна вэ? Энийг үе шаттай нэмэх ийм зүйлийг манай Байнгын хороо ярьж тогтоолын төслөөр оруулна гэсэн. Ийм юутай байгаа 1 дүгээрт ийм асуудал.

Хоёрдугаарт гэвэл энэ одоогийн энэ төсвийн төсөөллөөр шинэ хөрөнгө оруулагчийн анхаарлыг татахуйц ямар орлого, ямар зүйл, ямар анхаарал татахуйц ийм орлогын хэсэг гэж та нар юуг ингэж санал болгож байгаа вэ? Жишээ нь хөрөнгө оруулагчид энийг үзэж байвал юуг хараасай гэж та нар бодож байгаа вэ?

**О.Номинчимэг:** Энхбаяр Тэргүүн шадар сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Хөрөнгө оруулагчийг татах ний нуугүй хэлэхэд хөрөнгө оруулалтын орчноо бид туйлын муутгачихсан. Тэгэхээр хөрөнгө оруулалт нэмж байж эдийн засаг дахь эрх чөлөөг нэмж байж өмчийн халдашгүй дархан байдал бизнесийн нэр хүндийг бид нар хамгаалж байж хөрөнгө оруулалтыг татна аа. Засгийн газар хөрөнгө оруулалтыг татах бодлогын хүрээнд 1 дүгээрт эрчим хүчний салбарыг тавьж байгаа. Эрчим хүчний салбарыг төр хувийн хэвшлийн түншлэлүүд хэрэгжүүлэхээр нээж өгч байгаа. Сэргээгдэх эрчим хүчний болон нүүрс цахилгаан дулааны станцуудыг бүгдийг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт дээр тулгуурлаж хийж байгаа хөрөнгө оруулалт орж ирж байгаа бүтээн байгуулалт нь явж байгаа. Энэ бол гол чиглэл. Нөгөө талаар бусад дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг төр хувийн хэвшлийн түншлэлээр нээж байгаа.

Жишээлбэл Улаанбаатар замууд чиглэлийн олон улсын зам, Дархан, Алтанбулаг чиглэлийн зам, хил холболтын дэд бүтэц, төмөр зам, авто замуудыг дандаа төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

Үнэхээр хөрөнгө оруулалтын бодит байдал манай урсгал зардлын өндөр нэмэгдэлтэй холбоотойгоор зөвхөн 2027 онд гэхэд бид нар хамгийн багаар бодоход

4 их наядын нэмэлт зардал огцом үүсэж байгаа юм. Төсвийн орлого бол дутаагүй. Орлого бол ноднингийн мөн үетэйгээ адилхан даже 14 хувийн нэмэлттэй экспорт бүүр нэмэгдчихсэн, 60 хувийн экспортын илүү орлоготой буюу 2.2 тэрбум долларын илүү орлоготой. Байгаа орлогуудаа бид нар сайн цуглуулаад орлого бол тасралтгүй нэг хамгийн багадаа 10 хувь нэмэгдэлтэй л яваад байдаг. Бид нар урсгал зардлаа огцом нэмчихсэн. Урсгал зардал буюу цалин, тэтгэвэр дээрээ нэлээн өндөр ачаалал авчхаад тэр хэмжээнд хөрөнгө оруулалтаа хасахаас аргагүй байдал орж ирж байгаа.

Тийм болохоор дагасан хуулийг оруулсан. Дагасан хууль дээр НӨАТ-ын тухай хуулийг ингээд ярихад 1.8 их наядын төсвийн орлого дутахаар ийм тооцоо харагдаад байгаа юм. Тэгэх юм бол хийх бололцоотой 2.2 их наядасаа 1.8-ыг нь бид нар урсгал зардал, цалин, тэтгэвэр рүүгээ биш НӨАТ-ынхаа буцаан олголтдоо өгчих юм бол нөгөө цалин, тэтгэвэр нэмэх орон зай чинь нөгөө хөрөнгө оруулалт хийх орон зай чинь жоохон багасаад хязгаарлалтад ороод ингээд хүрэлцэхээ болиод эхэлж байгаа юм.

Тэгэхээр эдийн засгийн төлөв байдал бол ордог орлого олоод л татвар хураагддагаараа хураагдаад л ер нь өөдрөгдүү яваад байдаг. Урсгал зардлын огцом нэмэгдэлт арай огцомдчихсэн. Одоо дээрээс нь тэтгэврийн асуудлууд байна. Тэтгэвэр инфляцын асуудалтай холбоотойгоор төрийн албаны инфляцтай холбоотойгоор 8-10 хувь дээр нэмэлтүүд орно. Тэгэхээр төсвийн потенциал бол орлого, урсгал зардлаа гүйцэхгүй болж эхэлж байна аа. Хөрөнгө оруулалт хийх чадавхаа алдаж эхэлж байна л гэсэн үг.

Тэгэхээр бид нар эдийн засгаа томруулах, шинэ эдийн засаг мөнгөний урсгал оруулж ирэх, энэ бол ерөөсөө л хувийн хэвшил, төр хувийн хэвшлийн түншлэл, гадаад.

**О.Номинчимэг:** ЕБС-ийн үдийн хоолны хүртээмжийг сайжруулах асуудал дээр, урсгал зардал гэсэн. Энэ дээр Сангийн яам индрийн микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулья аа. Ер нь ЕБС-ийн хоол хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлыг Сангийн яамны хувьд байнга дэмжиж байгаа. Тэгэхдээ гол асуудал нь хэрэгжүүлэх арга барил маань бол бид нарын нөгөө нэг энэ төсвийн бодлоготой маань болохгүй байна гэдэг зүйлийг л хэлээд байгаа. Ер нь бол бидний гол засаг дээр ярьж байгаа асуудал юу вэ гэхлээр паблик сервис гэнэ үү, сивил сервис гэнэ үү энэ хуулиа оруулж ирье ээ. Гэхдээ энэ нь бол тухайн Дорж, Дулмаа гэсэн төрд ажиллаж байгаа иргэний хувьд биш, харин Дорж, Дулмаа гэсэн Монгол Улсын иргэний авч байгаа төрөөс авч байгаа үйлчилгээний тухай хууль байх ёстой гэдэг ийм зүйлийг л ярьж байгаа. Энэ дагуугаа гэх юм бол өөрөөр хэлбэл энгийнээр хэлэх юм блд боловсролын яам бол өөрөө хоол үйлдвэрлэлийн хэлтэстэй байгаад хоол үйлдвэрлэлийн тогооч бэлтгэгчээ бэлдээд тэд нар, хүмүүс нь төрийн албан хаагч байгаад 5 жилийн тэтгэмж аваад тангараг өргөөд ингээд ажиллах заавал шаардлагагүй ээ. Энийг хувийн хэвшил хийх боломжтой л гэж бид хараад байгаа юм.

Нөгөө талдаа болохоороо төр ганцаараа энэ дээр бол оролцож явахаасаа илүү эцэг эх нь бол өөрөө энэ төрийн үйлчилгээг авч байгаа хүний хувьд заавал хавсарч орж ирэх ёстой гэдэг зүйлийг бид яриад байгаа юм. Өөрөөр хэлбэл төрөөс бол хоол үйлдвэрлэлтэй холбоотойгоор бид хоолны материалын зардал болон

цалингийн болон энэ өртгийг нь эдийн засагт зах зээл дээр сонирхол татахуйцаар тогтоож өгье. Эцэг эх нь мянган төгрөгт ч гэсэн оруулаад хамтдаа ингэж орж ирээч ээ. Тэгсэн тохиолдолд Монгол Улсын иргэн төрөөс авч байгаа үйлчилгээг хянах боломжтой болно. Эндээ оролцох боломжтой болно оо гэдэг ийм агуулга бид нар яриад байгаа юм.

Тэгтэл нөгөө эсрэгээрээ төрийн албан хаагчдынхаа орон тоогоо л нэмээд л бид нар цаашдаа нөгөө дунд ангиа оруулахын тулд тэдэн тогооч хэрэгтэй, тэдэн бэлтгэгч хэрэгтэй гээд тэгээд бүх хөрөнгө оруулалтууд маань, сургуулиуд маань ингээд өөрөө ингээд гал зуухтай байгаад байхаар энэ маань болохгүй байна л гээд байгаа юм. Японд хүртэл зөвхөн ангидаа хоол идээд л явдаг бусдаар бол хоолыг бүх ангид л ер нь яваандаа өгөх ёстой гэдэг дээр бид төсвийн боломж байх л юм бол.

**О.Номинчимэг:** Баасанжаргал гишүүн тодруулъя.

**Х.Баасанжаргал:** Дэмжиж байгаад баярлалаа. Тэгэхээр энэ бодлогоо Засгийн газар энэ хувилбаруудаа гаргаж ирээд намрын төсөв дээр үе шаттайгаар нэг бөөнөөрөө биш шүү дээ яг тодорхой үе шаттайгаар тодорхой төлөвлөлттэйгээр энийг заавал намрын төсөв дээр оруулж ирэх хэрэгцээ шаардлага байна аа. Тэгэхгүй бол одоо бид нар дараа дараагийн үеийн залуучууд яг ахлах, дунд ангийнхныхаа энэ шим тэжээлийн байдал, бие бялдрын хөгжил гээд маш олон ирээдүйд залуучуудын маш олон эрүүл мэндийн аягүй олон асуудалтай бид нар нүүр тулах болчихоод байна. Тэгэхээр энэнээсээ бид нар энэ эрсдэлийг хамгийн бага байлгах хамгийн зохистой түвшинд барьж чадах төрийн хийж чадах энэ ажлуудаа хиймээр байна.

Тэгэхээр дараагийн намрын чуулган дээр энийг заавал барьж орж ирээсэй гэж бодож байна.

Дээрээс нь орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг энэ хангамжийн сүлжээндээ оруулах ийм бодлогыг бас давхар баримаар байна аа. Тэгэхгүй бол өчигдөр ХААЯ-ныхан ирээд энд энд ОНӨҮГ газар байгуулъя гээд яриад сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр тийм бодлого ерөөсөө баймааргүй. Яах гэж бид нар энэ олон зээл хөнгөлөлт цагаан алт гээд зөндөө олон хөнгөлөлттэй зээл бол олгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ААН-үүдэд энэ орон нутаг дахь зах зээлийг нь тэлж өгөөд яг энэ моделио намар гэхэд боловсруулаад энийг заавал энэ жилийн төсөв дээр тодорхой хэмжээгээр үе шаттайгаар оруулж ирмээр байна гэсэн ийм санал дээр манай Өргөдлийн байнгын хороо нэлээн хатуу байр суурьтай байна. Тэгээд бас холбогдох тогтоол, шийдвэрүүдийг бас гаргаж ажиллана шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

**О.Номинчимэг:** Үг хэллээ. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

**Ж.Галбадрах:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өчигдөр бас би Хүний хөгжил, нийгмийн бодлого дээр бас асууж байсан. Тэгээд бид дэмжиж байгаа. Энэ үзэл баримтлал юуг нь. Тэгээд зорилтууд өндөр тавигдсан тэгээд зорилтдоо хүрэхийн төлөө хичээх нь зөв гэдэг талаас нь ярьсан. Тэгээд бодит байдлаа бид нар бас сайн хараад энэ аюулын харанга цохиж байгаа улаан гэрэл асаасан энэ салбарууд дээрээ бас ийм бодитой төлөвлөгөө хийх нь зүйтэй.

Нэгдүгээрт энэ ядуурлын түвшнийг энд хэдэн хувиар бууруулахаар тэр ядууралтай тэмцэх ямар ямар тодорхой бодлогуудад тусгагдсан бэ гэдгийг асууя. Тэгээд өнөөдөр бол одоо үнэхээр ядуурал газар авч өдрийнхөө хоолны махыг ч авч чадахгүй байгаа иргэд бол маш их хэцүү ингэж ярьж байгааг бид нар өдөр тутам л сонсож байгаа. Тэгээд би бол өөрөө багш хүний хувьд олон улсын туршлагаас ч гэсэн харахаас ядуурлаас гарах юмыг бүүр уг үндсээр нь л бид нар авч үзэх ёстой. Олон улсад бол ядуурлаас гарах ганц гарц бол ерөөсөө л боловсрол чанартай боловсрол гэж үздэг. Тэгэхээр дэлхийн олон орон үүнийгээ баталсан. Солонгос, Сингапурын туршлагыг бид нар маш их ярьдаг тэр түүхийг нь ярьдаг. Хэчнээн ямар байдлаас ингэж гарч ирэв. Тэгээд тэнд боловсролынхоо чанарт л анхаарсан. Тэгээд тэр нь сайжирснаар боловсролын чанар сайжрахаар иргэн бүр бие даасан өөрийнхөө амьдралыг өөрөө өөрөө бие даагаад авч явах ийм чадвартай болохыг л бид нар хэлээд байгаа юм. Түүнээс тест бөглөөд оноо авах талын юмыг яриагүй.

Тэгэхээр энэ тал дээр бид нар анхаарах тэгээд эрдэм номыг эрхэмлэх, тэгээд боловсролоор дамжуулъя. Хүний тэр биеэ зөв авч явах, ёс зүйн хүмүүжил, боловсрол төлөвшил хандлага бүгдээрээ орж ирдэг. Тэгэхээр өмнөх хүрээнүүдэд, өмнөх жилүүдийн хүрээнүүдэд боловсролыг тэргүүлэх чиглэл байна. Мега хүний хөгжил бол манай Засгийн газрын мега төсөл байна эд нар гэсэн ийм зүйлүүдийг ярьж байсан. Тэгээд энэ зарчим юунуудыг энэ Засгийн газарт энэ хөгжлийн төлөвлөгөөнд, энэ хүрээнд хэр тусгасан бэ гэдгийг асууя. Тэгээд ер нь ингээд уншаад байж байхад бол салбарынхаа юуг их зөв тодорхойлоод эрэмбээ гаргаж ирсэн байгаа юм. Бид нарын хувьд бол сургуулийн хүртээмж хангалтгүй байна. Багшийн хомсдол дутагдалтай байна, сурлагын чанарын хоцрогдол дутуу байна гээд ингээд гаргаж ирсэн. Би энэ дагуу бас албан бичиг бас өгсөн байгаа. Би энийгээ тодотгол дээрээ асууя.

Тэгсэн мөртөө нөгөө нөгөө төлөвлөгөө дээр 2027 оны хөгжлийн төлөвлөгөө дээрээ ороод ирэхээр яг энэ зорилтуудаа хэрэгжүүлэхэд чиглэсэн биш яг үнэхээр хомсдолтой байдалд хүргээд байгаа багшийн хомсдолтой, багшийн дутагдалтай байлгаад байгаа сургуулийн хүртээмж хүрэхгүй байгаа талыг яг тэр талынх нь чиглэлд нь жишээ нь багшийн хомсдол дээр дутагдал дээр 0 төгрөг төлөвлөсөн байя.

**О.Номинчимэг:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Хөгжлийн гол суурь бол боловсрол, хүний хөгжил гэдэгтэй тантай санал нэг байна аа. Ийм учраас Засгийн газар энэ 2 жилийг боловсрол, эрүүл мэндийн жил болгож энд чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Зөвхөн боловсролын салбарт гэхэд 91499 багш, ажилтны цалингийн нэгдсэн сүлжээ, нэмэгдэл цалингийн асуудлыг шийдлээ. Тэгээд 37 цэцэрлэг, 57 сургууль гээд салбарын хөтөлбөрүүдийг та мэдэж байгаа.

Нөгөө талаас энэ боловсролоос гадна та энэ ядуурлын асуудлыг сая хөндлөө. Тэгээд энэ хүрээнд бол ганц боловсролоос илүү бид эрүүл мэндийн чиглэлийн хөтөлбөрүүдийг нэлээн идэвхжүүлсэн.

Дундаж давхаргыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, энэ ЖДҮ-лэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ сангуудаас нэлээн зарцуулалтуудыг бас байнга л нэмж хэрэгжүүлж эхэллээ. Тэгээд гол асуудал бид нар төсвийнхөө нөгөө боломж дээр л бүх асуудал очоод л хязгаарлагдаж байгаа. Харин боловсролын

салбар манай ДНБ-ий 7 хувьд хүрсэн. Нийт улсын төсвийн 20 хувийг боловсролын салбарт зарцуулж байгаа. Энэ их өндөр тоо. Бас чамлахааргүй байна. Сая энэ өнгөрсөн 2 жилийн хугацаанд манай парламент Засгийн газрын их том хүрсэн үр дүн энэ боловсролын салбарт хийгдсэн ажил хөрөнгө оруулалтууд гадаад зээлээр гол гол төслүүд эх үүсвэрээ олчихсон. Цалин, нийгмийн хамгааллын асуудлаа урагшлуулчихсан их боломжийн байгаа. Тэгэхээр бид нар эдийн засгаа л тэлэх асуудлаа л ахиж хэлье. Их цаг алдаад байна л даа. Үнэхээр Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг эхлэх гэж хэдэн жилийн маргаан дагуулав? Энэ хооронд чинь л жил болгон 90 сая долларын цахилгаан бид нар ОХУ-аас импортлоод л баруун 5 аймгаа хангаад л байгаа байхгүй юу. Барьчихсан бол аль хэдэн тэрбумыг хэмнээд төсөвтөө оруулчих хэмжээг л бид нар алдаад л явуулж байна. Уран дээр бас арваад жил алдлаа. Одоо ингээд газрын ховор элемент, Халзан бүргэдэйн асуудал дээр ид улс төржиж байна.

Ингээд хэрэгжүүлэх гэсэн ингээд томоохон боломжууд дээр ерөөсөө ажлууд явахгүй байгаа байдал байна. Тэгэхээр энэ эдийн засгийг жоохон эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг хамгаалах, гаднын хөрөнгө оруулалтыг урих, эдийн засаг төрийн оролцоог бууруулах ийм бодлогын арга хэмжээг эрс хатуу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхгүй бол одоо байгаа эдийн засгийн потенциал чадавх маань үндсэндээ тулж байна. Үүнээс илүү одоо байгаа суурилагдсан хүчин чадал энэнээс илүү орлогыг төсөвт оруулах бололцоо хязгаарлагдмал болж байгаа юм. Бүхий л асуудал уул уурхай нь ч тэр, тээвэр нь ч тэр, эрчим хүч нь ч тэр тулж байна. Тэгэхээр бид нар шинэ эрчим хүч, шинэ станц, шинэ төмөр зам, шинэ ОТ, шинэ Тавантолгойнууд, шинэ ашигт малтмалын орд газар ашиглах, боловсруулах үйлдвэрээ хөгжүүлэх, шинэ зах зээл рүү гарах гэдэг юм уу ийм эдийн засгийг тэлэх бодлогоо л онцгой анхаарч хэрэгжүүлэх хэрэгтэй болж таарч байна.

Тэгэхгүй бол хуримтлагдсан энэ нийгмийн олон асуудлыг яаж хичээгээд бодоод бодоод бодын шийр хэд вэ гэдэг шиг хэмжээ маань ингээд ханачихлаа тулаад эхэлж байна.

**О.Номинчимэг:** Галбадрах гишүүн тодруулъя.

**Ж.Галбадрах:** Тийм. Макро түвшинд эдийн засгийг тэлэх тал дээр ингээд баримталж байгаа бодлогууд эд нарыг бүгдийг дэмжиж байгаа, харж байгаа. Энэ одоо хуулиуд дээр дэмжээд явна. Миний хувьд бол боловсролын салбарын эксперт гэдгээрээ л ерөөсөө л оногдсон тийм цаг дээрээ энэ юун дээрээ салбарынхаа юмыг яриад байгаа. Би Эдийн засаг хөгжлийн яаманд бол бас албан бичиг явуулсан. Энэ дээр энэ багш хомсдолын энэ талаар сая би хэлсэн. Төлөвлөгөөнд ерөөсөө багш дутагдлыг арилгах гэгчхээд ерөөсөө улсын төсөвт нэг ч төгрөг төлөвлөөгүй л байсан. Би тэгвэл энэ дээр нэг 60-аад тэрбум төгрөг жилдээ төлөвлөөд байвал бид нар тоон болон чанарын хомсдолоос гарч чадах юм аа. Үүний тулд зах зээл дээр байж байгаа багш мэргэжилтэй мөртөө багшаа хийхгүй байгаа хүмүүсийг эргүүлэн ирүүлэх ком бэк хийлгэж багшийнх нь ажлыг нь хийлгэхийн тулд бас эдийн засгийн хөшүүрэг гаргаад явбал болох нь ээ.

Үнэхээр бид нар багшгүй болчихоор тэгээд л ирээдүй болсон энэ улс орныхоо хөдөлмөрийн нөөц ирээдүй болсон хүүхэд багачуудыг сургах гэдэг асуудал маань байхгүй ямар ч боломжгүй болчихно. Тэгэхээр энэ тал дээр нь бичсэн юм байгаа юм.

Нэгдүгээрт нөөц.

Хоёрдугаарт, багш яагаад ажлаас гараад байгаа вэ гэвэл тэр ажлын байрны нөхцөл буюу нэг багш болчихоор ирээдүйд тэгээд л насаараа багш болж байгаа бол энэ хүмүүсийг нэг карьерыг нь тодорхой болгоод, бас магистрт дахин давтан сургалтад гадаад оронд ч юм уу ингээд явуулж сургах тал дээр нь шилдэг хүүхдүүдийг, оюутнуудыг бас багш нарыг, төгсөгчдийг ажиллуулъя.

Гуравдугаарт нь гээд шилдэг ЕБС-ийн төгсөгчдийг төрөлх сургуульдаа ирж ажиллах нөхцөл бололцоог гаргая. Тэгээд энэ дээр хэд хэдэн оюутан жилд байж болвол одоогийн энэ дутагдаад байгаа юм гарах вэ гэдэг дээр хэн их өгөгдөл дээр нь суурилад энэ тооцоолуудыг хийсэн юм байгаа юм. Тэгээд ингэж хэлээд энэ Мөнхсэлэм дарга байж байна. Бид энэ албан бичиг ингээд өгч байсан юм. Тэгэхээр энэ тал дээр ямар хариу байгаа вэ?

**О.Номинчимэг:** Энхбаяр сайд хариулъя.

**Ж.Энхбаяр:** Таны гаргаж байгаа санал асар их үнэтэй санал. Тантай үнэхээр санал 100 хувь нийлж байгаа. Нөгөө ахиад л төсөв ярих гэж байна. Энийгээ орхиод ер нь тэгээд сая Боловсролын яам, ер нь бүхий л яамдууд нөгөө дотоод үйл ажиллагаан дээрээ үнэлгээ хийгээд чиг үүргийн шинжилгээ хийгээд нягтруулах ажлууд хийж байгаа.

2030 он гээд үндсэндээ цэцэрлэгийн асуудал шинээр нэмж барих шаардлага багасаад эхэлнэ. Орон нутагт 12 жилийн сургуулийн шаардлага байхгүй болоод эхэлнэ. Нийслэл дээр тодорхой байрлалууд дээр сургуулийн хэрэгцээ үлдэнэ. Тэгэхээр нягтруулах бодлогуудыг, жишээлбэл сум дундын зохион байгуулалтууд, 12 жилийн сургуулийг сум болгонд биш, зарим суманд 7 хүүхэдтэй, 12 дугаар анги, 5 хүүхэдтэй 9 дүгээр анги, 8 дугаар анги гэх мэтийн нэг ийм анги дүүргэлтгүй нөгөө талдаа асар их урсгал зардалтай нэг ийм. Тэгээд энийгээ дагаад багшийн дутагдалд орсон. Энийгээ дагаад сургалтын чанар унаж байгаа нэг ийм зүйл нэлээн түгээмэл анзаарагдаад эхэлсэн. Тэгэхээр нягтруулах ажлуудаа нэлээн Боловсролын яамны сайдын хэлж байгаагаар бол бага сургууль, бага боловсрол дээрээ нэлээн хотхондоо гэрийн ойр орчимд одоо сулрах цэцэрлэгүүд дээр тулгуурласан бага боловсролынхоо бодлогоо нэг явуулъя. Хүрэлцээгээ хангая. Ахлах сургуулиудыг нягтруулах маягаар сум дундын байна уу, аймгийн төвийн тэр сургуулиуд дээр илүү төвлөрүүлээд суманд илүү дунд боловсрол талдаа анхааръя гэдэг маягаар багшийн хүрэлцээгээ хангая, нягтруулъя, тэгээд хүн амын тэр эрэлт нийлүүлэлт тэр цонх үеийн мөчлөгүүдийг сайн тооцоолж хөгжлийнхөө бодлогодоо анхааръя гэсэн байдалтай ийм тайлбарууд бас өгч байна лээ. Ийм бодлого бас явуулж байгаа юм байна лээ гэдгээ бид нарт бас тайлбарлаж хэлсэн.

Тэгэхээр ахиад л төсвийнхөө эх үүсвэрүүдээ л бүгдээрээ яаж ийгээд л гаргах л асуудал.

**О.Номинчимэг:** Би нэг асуулт асуучихъя. Би их тодорхой асуулт асууна аа.

Манай Өргөдлийн байнгын хороон дээр ер нь орж ирж байгаа, иргэдээс ирж байгаа өргөдлүүд, нийтийн өргөдлийн системийг харахаар ер нь 3 зүйл л иргэдээс хүсээд байгаа. Нэг нь ерөөсөө энэ амьдрах орчинтой холбоотой, энэ болохгүй байна тэр нь болохгүй байна, зам харгуй юу гэдэг юм хот тосгонд ингээд амьдрахад ийм байна тийм байна гээд.

Хоёр дахь нь шударга бус байдал. Төрийн үйлчилгээ чинь шударга бус байна. Хүний эрх зөрчигдөж байна ийм асуудлууд.

Гурав нь ерөөсөө амьжиргаатай холбоотой асуудлууд. Ерөөсөө л эдийн засгийн нөхцөл байдал иргэдийн өрх өрхийн амьжиргаатай холбоотой асуудал. Тэтгэвэр бага байна энийгээ нэмээч, мах мах авч чадахаа болилоо. НӨАТ чинь дарамт нь өндөр байна багасга. Хүн амын орлогын албан татвар чинь бага байна багасга татвараа бууруул. Энэ нөгөө нэг татварт дургүйдээ гэхээсээ илүү авч байгаа цалин нь олж байгаа орлого нь ерөөсөө энэ үнийн инфляцаас үүдээд авах худалдан авалтын чанар нь өдөр бүр муудаад байна.

Тэгэхээр энэ амьжиргаа муудаж байгаагийн л илрэл шүү дээ. Иймэрхүү хүсэлтүүд иргэдээс их ирээд байна гэхээр тэгээд төсвийн хүрээний мэдэгдлийг бол Засгийн газраас 5 сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Би бас чуулган дээр хэлж байсан. Та бүхэн ингээд орлого зарлагаа харахаар төсвийн нэгдсэн суурь тэнцэл маань нөгөө хуульд заасан хамгийн дээд хязгаар буюу 2 хувь дээрээ шахаад ороод ирчихсэн байгаа. 2027, 2028, 2029 онд ямар ч орон зай байхгүй. Гишүүд ч гэсэн хэлсэн. Гадаад нөхцөл байдал чинь ийм байна, инфляц чинь ийм байна. Тааварлашгүй нөхцөлүүд эрсдэл их байхад та нар эрсдэлийг юу гэх юм шингээх энэ орон зай байхгүйгээр тулгал нь 2 хувьд нь суурь тэнцлээ ингээд оруулаад ирчихсэн байна гээд. 5 сарын 7-нд буюу төсвийн хүрээ өргөн баригдсанаас 6 хоногийн дараа Засгийн газраас Татварын багц хуулийг өргөн барьсан. Энэ бол яалт ч үгүй иргэдийнхээ тэр нөгөө амьжиргаатай холбоотой татварын дарамт худалдан авах чадвартай холбоотой энийг нь хөнгөвчилье. ААН-үүддээ бас боломж олгоё оо гээд энэ иргэдийн хүслийг шингээсэн ийм бодлогыг оруулж ирж байгаа сайшаалтай арга хэмжээ авч байна аа.

Тэгээд би харахаар энэ 2-ын хооронд уялдаа холбоо Засгийн газар дээр 6 хоногийн зайтай хийгдэж байгаа болж хийгдээгүй байгаа юм уу гэж бодоод байгаа юм. ХЗБХ-н дээр өчигдөр би асуусан. Энэ татварын багц хууль дээр орж ирж байгаа татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн чинь тооцоолол та хэдийн төсвийн хүрээний мэдэгдлийн энэ тооцоолол дээр орсон юм уу? Олох орлого чинь багасахаар байна тийм үү? Тэгээд олох орлого чинь багасаад ирэх юм бол нөгөө одоо энд хуулийн хязгаар гээд байгаа 2 хувиас чинь ихсэх гээд байна. Энийгээ та нар хийж ирсэн юм уу гэдэг л юмыг асуугаад байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр би 2 хүнээс асуумаар байна. Мэдээж Засгийн газар төлөөлж байгаа Энхбаяр сайд энэ дээр яг ямар нөлөөлөл гарч ирээд энэ дээрээ тусгаж яах болж байна? Эсвэл одоо энэ Улсын Их Хурал дээр хэлэлцүүлгийн шатанд энэ зарлагыг нь бууруулах ч байдаг юм уу энэ асуудлаар яагаад энэ төсвийн юуны хязгаар 2 хувьдаа яг баригдахаар дахиж зарлагаа бууруулж өгөх юм уу? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асуумаар байна. Та бүхэн ч гэсэн энэ макро түвшинд нь харж байгаа байх. Татварын багц хууль орж ирснийг ч харж байгаа байх. Энэ Засгийн газрын оруулж ирсэн энэ дунд хугацааны төлөвлөлт дээр орж уу, ороогүй бол та бүхэнд яаж өөрчлөх ёстой гэсэн мэргэжлийн байр суурь байгаа вэ? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Тэнцвэржүүлсэн тэнцэл маань 1.5 хувь, 1.7 их наяд. Энэ бол энэ хэмжээгээр нөгөө гадаад зээл ашиглалт 1.7-оор орж ирдэг гэсэн үг. Тэгэхээр тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 34.7-оос энэ суурь тэнцэл гээд байна шүү дээ

энэ чинь бол дотоодын нийт бүтээгдэхүүн 2 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай ажиллах ашиг байхгүй, ашигтай байна аа. Орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээ 2-ын зөрөө 2 хувь. Энэ чинь ашиг.

Энэ ашгаараа бид нар нөгөө гадаад зээл төлбөрийнхөө үйлчилгээгээ хангаад явдаг. Алдагдал тэнцвэржсэн тэнцэл буюу орлого, зарлагын тэнцэл чинь 1.7 буюу ДНБ-ий 1.5 хувь, 1.7 их наяд гэдэг чинь нийт орсноосоо илүү зарна. Зарлага энэ 1.5 хувь буюу 1.7 их наядыг гадаад зээлээр санхүүжүүлнэ л гэсэн үг. Тэгэхээр энэ нийт орлого зарлага дээр ямар нэгэн хөдөлгөөн орохгүй. Энэ бол яг төсвийн тусгай шаардлагадаа нийцүүлээд оруулж ирж байгаа тоонууд шүү. Энэ тоо хөдлөхгүй тоонууд.

**О.Номинчимэг:** Энхбаяр сайд миний бодлоор энэ төсвийн хуулийг энэ хязгаарыг буруу тайлбарлаад байх юм. Сангийн яам тайлбарлах юм уу? Та нар дээд хязгаартаа оруулаад л ирчихсэн байгаа шүү дээ. Одоо тэгээд орлого чинь буураад ирэхээр энэ тоо чинь ихэснэ шүү дээ. Тэгэхээр нөгөө хууль зөрчих гээд байна шүү дээ. Одоо Төсвийн тогтвортой байдал чинь энэ дээр дүгнэлт гаргаад 2 хувь дээрээ л яах вэ ингээд яачихсан байна. Ямар ч орон зайгүй байгаа гээд төсөвлөчихсөн байна, төлөвлөчихсөн байна гэж хэлээд байгаа биз дээ. Тэгвэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хариул энэ дээр. Сангийн яам бас бэлдэж бай. Энэ ойлгомжтой асуудал биз дээ. Энхбаяр сайд бас ингэж гуйвуулж болохгүй энэ чинь.

Төсвийн тогтвортой байдал энэ микрофоныг нь юу гэж хэлэх билээ. Индэр дээр очиж хариулах юм байна.

**Н.Ууганбаатар:** Би Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ууганбаатар байна. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Би гишүүний асуултыг хөндөх ёстой асуудал мөн болов уу гэж бодож байна. Бид 3 сард тухайлбал төсөөлөл боловсруулж өгөхдөө 2 хувилбартайгаар өгсөн. Нэг нь татварын реформ хийгдвэл орлого зарлага болон макро эдийн засгийн үзүүлэлтүүд ямар байх вэ хийгдэхгүй байвал ямар байх вэ гэдэг дээр 2 ийм хувилбартай 2 хүснэгт өгсөн гэсэн үг. Яагаад вэ гэхээр тухайн үед Татварын хууль өргөн баригдчихсан байсан. Татварын реформ өргөн баригдчихсан байсан сүүлд нь та бүхэн мэдэж байгаа байх энэ өөрчлөлт буцаагаад татсан сая тэгээд дахиад шинээр өргөн барьсан. Тэгэхээр энэ дээр бол зөрөө гарах ёстой. Орлого дээр ялангуяа тодорхой хэмжээний дүнгийн өөрчлөлт гарах болов уу гэж бодож байна. Суурь тэнцлийн хувьд бол асуудал жаахан өөр. Яагаад гэхээр суурь тэнцэл чинь нийт орлогоосоо бид нар яах вэ гэхээр суурь зарлага гэдэг юмыг хасаад гаргаж байгаа. Суурь зарлага хэсэг дээр нь бол нийт зардлаасаа зээлийн ашиглалт хасчихдаг.

Тэгэхээр орлого буурлаа гээд яг тэр хэмжээгээр суурь тэнцэл буурна гэсэн ойлголт бас байхгүй. Энэ дээр бас Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өнгөрсөн хугацаанд нэлээн хэлж ирсэн. Манай суурь тэнцэл бол ингээд эдийн засгийнхаа мөчлөгийг жоохон мэдрэхгүй дандаа л 2 хувь, 2 хувь гээд л яваад байна гээд ингэж хэлээд л сануулаад л яваад байгаа. Тэгэхээр энэ суурь тэнцэл гэдэг ойлголт маань өөрөө жоохон онцлогтой. Яагаад вэ гэхээр зээлийн ашиглалтаа нэмээд суурь тэнцлийг ер нь сайжруулах боломжтой. Орлого буурсан тохиолдолд.

**О.Номинчимэг:** Тэгвэл 1.5-ын чинь дээд хэмжээ нь 2 хувь байх ёстой. Энэ орлого буурлаа гээд та бүхэн тэгвэл 2 хувьдаа баригдана гэж тооцоолж байгаа юм уу? Гадаад зээлийн ашиглалтаас холбоотой энийгээ тэгвэл Засгийн газар оруулж

ирэхгүй бол энэ нөгөө төсөөлөл чинь тэгвэл худлаа болох гээд байгаа юм байна тэ? Гадаад зээлийн ашиглалт чинь Эрдэнэбүрэний УЦС газрын тосны юутайгаа нөгөө хууль маань уначхаад байгаа шүү дээ. Хамаагүй юм уу тооцоолчихсон юм уу? Тэр хууль батлагдана гадуур нь байна гэж тооцоолоод энэ дээр оруулаад ирчихсэн гэж ойлгож байгаа юу? Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Энэ тэнцвэржүүлсэн тэнцлээр энэ гадаад зээлийн ашиглалтын тоо гарч ирнэ. Энд нөгөө Монгол Улсын Засгийн газрын амлуулсан 18 их наядын гадаад зээлүүд жагсчихсан байгаа шүү дээ. Гол нь бид нар энэ тоондоо багтаах гээд 10 наймаасаа шахаад л төслүүдээ сунжруулаад л, хэрэгжих хугацааг нь хойш нь тавиад байгаа байх асуудал байхгүй юу. Тэгээд Эрдэнэбүрэний УЦС, Алтан ширээ нефть боловсрох үйлдвэр чинь их том дүнтэй болохоор энэ зээлийн ашиглалтыг чинь дүүргэхээд бусад эрүүл мэндийн боловсролын ХАА-н орон нутгийн дэд бүтцийн эрчим хүчний төслүүд чинь энд багтаж орж ирэхгүй байгаа юм. Тэгэнгүүт энийг нь төсвөөсөө гаргаад тавьчихаар энэний үүссэн орон зайн дээр нөгөө бусад төслүүд чинь хэрэгжээд эхэлж байна гэсэн үг л дээ. Тэгээд энэ дээр бас бид нар болгоомжтой хандаж 2 биш 1.5 байхад хангалттай.

Дээрээс нь тэр суурь тэнцлийн 2.2 их наядын нэмэх гэж ашигтай гарна гэж байна шүү дээ. Энэ хэмжээнд бас гадаад зээлийн ашиглалт бас орж ирж байгаа. Ингээд нийт 4 их наядын гадаад зээлийн ашиглалт байна. 4 их наядын гадаад зээлийн ашиглалтаас бид 2 том төслөө гаргаад ирэхэд бусад салбарын маш олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжинэ ээ. Энэ нь эдийн засгаа идэвхжүүлэх мөнгөний нийлүүлэлт эдийн засгаа дэмжсэн бодлого болох юм аа?

**О.Номинчимэг:** Ойлголоо энэ тоо нь тэгвэл тэр тэнцвэржүүлсэн тэнцэл дээрээ яам, та бүхэн бас нарийвчилсан тоонуудаа. Энийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч гэсэн бас энэ хэлэлцүүлгийн явцад Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороон дээр энэ чинь эцэслэгдэж явах ёстой бас анхаарч ажиллаж байгаа байх гэж ойлгож байна. Түрүүн хэлсэн Баасанжаргал гишүүн хэлж байсан. Энэ үдийн хоол ЕБС үдийн хоолны хөтөлбөрийн асуудлаар иргэдээс ирсэн өргөдлийн дагуу бид бас ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Энэ бол заавал явах ёстой асуудал шүү. Бид нар бас Улсын Их Хурлын тогтоол боловсруулж ажиллаж байна. Тэгээд хүндээ хөрөнгө оруулахгүй бол баахан цагдаа юуны байшин бариад тэгээд 1 ийм хөгжчихнэ гэсэн байдлаар явж болохгүй. Манай улс нэг их тийм аймаар мөнгөгүйн зовлонд орчхоод байгаа юм нь гайгүй. Нэг их тийм их ч мөнгө биш шүү дээ. Тэгээд тийм мөнгөө өдий хүртэл хүүхдүүдээсээ харамлаж ирсэн. Энэний өөрийнх нь хөрөнгө оруулалтынх нь үр өгөөж нь олон жилийн дараа маш том байдаг. Тэгээд энийг л манай Засгийн газар бас ойлгож яг энэ 2027 оны төсөв дээрээ энийг нь та бүхэн Боловсролын яамнаас ерөнхийдөө тоон мэдээллийг нь татаад авчхаж үзэж байгаа байх. Тэд нар ч гэсэн санал гаргаж байгаа байх. Энэ дээр бас та бүхнийг анхаараад ажиллаарай гэдгийг бас хэлмээр байна аа.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ ээ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанд Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц байгаа юу? Байнгын хороонд давхцаж байгаа юу. Эдийн засгийн байнгын хорооны байгаа биз дээ тийм үү? Галаа гишүүн байдаггүй юу? Энэ давхардсан байдаг гишүүдээс буюу Золжаргал гишүүн, Пунсалмаа гишүүдээс танилцуулъя. Хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

16.10 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА